

АГУУЛГА

Өмнөх үг

Булган аймгийн түүх

БҮЛЭГ 1. Хүн ам зүйн байдал

БҮЛЭГ 2. Хөдөлмөр эрхлэлт

БҮЛЭГ 3. Нийгмийн үйлчилгээний салбарууд

3.1 Боловсрол, соёл, урлаг

3.2 Эрүүл мэнд

БҮЛЭГ 4. Дотоодын нийт бүтээгдэхүүн

БҮЛЭГ 5. Хэрэглээний бараа үйлчилгээний үнэ, тариф

БҮЛЭГ 6. Үйлдвэрлэл, үйлчилгээний салбарууд

6.1 Хөдөө аж ахуй

6.2 Аж үйлдвэр

6.3 Барилга, тээвэр

БҮЛЭГ 7. Аж ахуйн нэгж, байгууллагын тоо, бүтэц

Хавсралт

Өмнөх үг

Аймгийн статистикийн хэлтэс нь орон нутгийн хэмжээнд статистикийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн асуудлаар танилцуулга, судалгаа бэлтгэж тархаах үндсэн чиг үүрэгтэй, 9 ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Үндсэн 5 ажилтан, гэрээт 2 ажилтан, өрхийн нийгэм эдийн засгийн болон ажиллах хүчний судалгааны гэрээт судлаач 2 ажиллаж байна. Үндсэн ажилтнууд бүгд статистикч, эдийн засагч, мэдээлэл технологийн чиглэлийн мэргэжлийн ажилтнууд байгаа бөгөөд судлаачид ч мөн статистикч, эдийн засагч мэргэжилтэй байна.

Хэрэглэгч та бүхэнд толилуулж буй Ховд аймгийн нийгэм, эдийн засгийн байдлын энэхүү танилцуулга, холбогдох тоо мэдээллийг аймаг, орон нутгийнхаа хөгжлийн бодлого, хөтөлбөр боловсруулах болон шинжилгээ судалгааны ажилд өргөнөөр ашиглахыг хүсье.

Танилцуулгын болон статистикийн мэдээллийн талаар өөрийн санал хүсэлтээ бидний хаягаар ирүүлбэл талархан хүлээн авч хамтран ажиллах болно.

Хаяг: Булган аймгийн Засаг даргын Тамгын газрын байр, өрөө 101

Утас: 70342369

70342766

Факс: 976-70342369

Цахим хаяг: bulgan@nso.mn

Веб хуудас: <http://www.nso.mn/bulgan/>

БУЛГАН АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

Булган аймгийн товч түүх

БНМАУ-ын Ардын сайд нарын Зөвлөлийн 1937 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 33 дугаар тогтоолоор Сэлэнгэ аймгийг Булган, Сэлэнгэ хоёр аймаг болгон тусгаарлан байгуулжээ.

Ардын Сайд нарын Зөвлөлийн Ерөнхий сайд А.Амарын 1937 оны 12 сарын 27-ны өдрийн 241-р тушаалаар Булган аймгийг 15 сум, 128 баг, 10360 өрх, 43500 хүн амтай, 1,1 сая малтай, 42250 хавтгай дөрвөлжин км нутагтай байгуулж, Сэлэнгэ аймгаас Сайхан, Хантай, Сэлэнгэ, Булган, Сэлэнгэбүрэн, Халиун, Хангал, Цонхлон сум, Төв аймгаас Бүрэгхангай, Авзага сум, Хөвсгөл аймгаас Тэшиг, Хутаг-Өндөр, Намнан, Баян-Агт сум, Архангай аймгаас Могод сумыг Булган аймагт харъяалуулан захируулах болжээ.

Мөн 1938 оны 1 дүгээр сард Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн, Орхонтуул сумыг Булган аймагт шилжүүлжээ. Булган сумын төвд байгаа хүн, малын эмнэлэг, хоршоо, банкны салбар, бага сургууль, утас /холбоо/-ны хороог аймгийн байгууллага болгон өргөтгөж, шинээр улсын худалдааны бааз, хоршоодын холбоо, дунд сургууль, шүүх таслах газар, прокурор, дотоод яамны анги, засал сайжруулах /хорих/ газар, гар үйлдвэрийн төлөөлөгч, ойн анги, тээх нэвтрүүлэх, клуб, радио станц зэрэг газруудыг тус тус байгуулжээ.

Дэлхийн II дайн дэгдэж, манай улсын дорнод хилд Японы түрэмгийлэгчдийн аюул занал ихэсчээ. Ийм үед батлан хамгаалах хүчийг бэхжүүлэхэд улс орны бүх ажил үйлс чиглэгдэж байсны дээр улс төрийн хэлмэгдүүлэлтийн хар шуурга монголын нийгмийг хамарсан хатуу бэрх цаг байв. Шинэ тутам байгуулагдсан Булган аймаг юуны өмнө мал аж ахуйг хөгжүүлэхэд гол анхаарлаа төвлөрүүлэн, улсаас зээл авч, Булган, Хантай суманд өвс хадах морин ба машин тракторын станц, Авзага, Хантай, Хутаг-Өндөр, Цонхлон зэрэг 10 суманд гар үйлдвэрийн артель, ардын үйлдвэрлэлийн нэгдэл, 6 суманд сургууль, бүх суманд хүн, малын эмнэлэг, 15 суманд сүү тосны завод байгуулах зэрэг том асуудлыг 2-3 жилд амжилттай хэрэгжүүлж чадсан юм. Мөн аймгийн төвд радио телефон станц, 5 суманд утсан харилцаа холбоотой болсон байна.

Дайны үед орон нутгийн нөөц баялаг ашиглах, ялангуяа газар тариаланг хөгжүүлэх, сүү тосны болон гар үйлдвэрийг хөгжүүлэхэд ихээхэн амжилт гаргаж, 1942 оны төлөвлөгөөт бүх зорилтыг давуулан биелүүлж, улсын тэргүүний аймгаар шалгарч, “Хөдөлмөрийн гавъяаны улаан туг”-ийн одонгоор шагнагдсан байна.

1943 онд Ингэттолгойд улсын сангийн аж ахуй байгуулагдсан нь газар тариалангийн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэжээ. Тус аймаг 1943 онд 1,3 сая толгой малтай, 8000 тн үр тариа хураан авдаг болжээ.

Дайны дараа энх тайван цагийн бүтээн байгуулалт эхэлсэн буюу анхдугаар таван жилийн төлөвлөгөөний жилүүдээс эрхлэн тус аймаг тогтмол амжилт гаргаж, 1961, 1972 онд бүх ард түмний социалист

уралдаанд шалгарч шагнал хүртэж байжээ.

Булган аймаг нь Монгол орны төвийн хойд хэсэгт 48.8 мянган ам км буюу Монгол орны нутаг дэвсгэрийн 3,1 хувийг эзлэж, хангайн уулархаг ойт хээрийн бүсэд оршдог.

Нийт талбайн 70.0 хувь нь ХАА-н эдэлбэр газар үүнээс 2.4 хувь тариалангийн газар, 2.3 хувь нь хадлангийн, 58.5 хувь бэлчээрийн, 28.7 хувь ой, 0.5 хувь усан талбай, 2 хувь нь тусгай хэрэгцээний болон нөөцийн газар болно.

Хангайн нурууны салбар бэсрэг уулс Хантай, Булган хан, Ханжаргалант, Дулаан хан, Намнан, Хутаг-Өндөр, Онгон сарьдаг, Сардиг Бүтээл, Бөхөн шарын нуруу, Бүрэн хан, Могодын нуруу, Авзага хайрхан, Бүрэгхангай, Дулаан хар, Хөгнө хан, Лах баян, Өрхтэй, Баянзүрх, Баян-Агт зэрэг **2000** метрээс дээш өндөр 20 гаруй уул нуруудтай.

Хамгийн өндөр цэг нь **Хантай нурууны оргил Давлан 2171 метр**, хамгийн нам дор газар нь Сэлэнгэ мөрний сав Сүмийн Булан, Итгэттолгой орчим далайн түвшнээс дээш **950 метр** оршдог.

Сэлэнгэ, Эг, Орхон, Туул, Хануй, Хар бух, Тарвагатай, Тарни, Хангал, Ингэт, Хужир, Баян гол, Зэлтэр, Алтайд, Ачуут, Могой, Төлбөр, Балиг, Цагаан гол зэрэг 380 гаруй ариун уст гол горхи, 370 шахам булаг шандтай, Хунт, Хульж, Хануй, Цагаан гол, Чин толгой, Чулуут, Хөөвөр, Зүүн түрүү зэрэг 30 орчим анагаах чадалтай рашаантай.

Харгал, Олон нуур, Цэгээн, Шарга, Айрхан, Хунт, Өрмийн цагаан, Чингийн цагаан, Баяннуур, Галуут зэрэг 71 нууртай. Газар тариаланд тохиромжтой хар ба хар хүрэн бор болон саарал хөрстэй. Хуш, хус, хар мод, улиас, нарс, бургас, хайлаас, яшил, яргай, чаргай зэрэг шилмүүст ба навчит модтой.

Хандгай, буга, баавгай, үнэг, чоно, булга, суусар, хэрэм, жирх, ирвэс, шилүүс, хүдэр, үеэн, мануул, чандага зэрэг амьтан, тас, бүргэд, ёл, хур, сойр, улаан хошуут, турлиах, ятуу, сар, шувуу зэрэг шувууд, тал хээрт үнэг, хярс, тарвага, зурам, өмхий хүрэн зэрэг амьтад элбэг.

Гол мөрөн нуур цөөрөмд төрөл бүрийн загас тул, хэлтэг алгана, цурхай, гутиар зэрэг загас элбэг. Хун, ангир, галуу, нугас, тоодог, цэн тогоруу, өрөвтас, халбаган хошуут зэрэг агаарт элэн халин нисэх жигүүртэн шувуудтай.

Төрөл бүрийн жимс жимсгэнэ, эмийн ургамалтай.

Уур амьсгал нь эх газрын, эрс тэс сэрүүвтэр чийглэг, үнэмлэхүй дулаан 34.8 хэм, үнэмлэхүй хүйтэн -44.1 хэм, жилийн дундаж тундас 324 мм

боловч зарим жил 500 мм-ээс дээш ч байдаг. Салхины дундаж хурд 2.2 м/сек, цасан бүрхүүлийн дундаж зузаан 15-25 см байдаг.

Байгалийн нөөц, ашигт малтмалаас алт, мөнгө, зэс молибден, хар тугалга, чулуун нүүрс, оюу, номин, болор, гантиг боржин чулуу, барилгын төрөл бүрийн эрдэс баялагтай, элс, хайрга, хүрмэн ба шохойн чулуу, зос будаг зэрэг элбэг.

БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн зарлигаар 1961 онд Булган аймгийн төвийг Булган хот болгож, хотын захиргаа байгуулжээ.

Булган хот далайн түвшинээс 1210 м өндөрт өргөгдсөн, Улаанбаатар хотоос 318 км, Сэлэнгэ аймгийн төв Сүхбаатар хотоос 360 км, Төв аймгийн төв Зуун мод хотоос 340 км, Хөвсгөл аймгийн төв Мөрөн хотоос 330 км, Архангай аймгийн төв Цэцэрлэг хотоос 330 км, Өвөрхангай аймгийн төв Арвайхээр хотоос 360 км зайд, дөрвөн замын уулзварт байдаг. Монгол орны хүйс цэг Өвөрхангай аймгийн Бүрд сумаас 230 км, Монголын эртний нийслэл Хархорум/ Эрдэнэ зуу/-оос 320 км-т оршдог.

Булган хотод 1948 онд хүнсний үйлдвэр, 1951 онд дизель цахилгаан станц, авто тээврийн бааз, 1960 онд барилгын үйлдвэр байгуулагдсан.

1958 онд Монгол Улсын анхны томоохон Гурилын үйлдвэр ашиглалтанд орсноор хүнсний анхны том үйлдвэртэй болжээ.

1965 онд Эрчим хүчний үйлдвэртэй болж, 1980 онд Эрдэнэтээс өндөр хүчдэлийн шугам татсанаар төвийн эрчим хүчний системд холбогдож байнгын тасралтгүй эрчим хүчээр хангагдсан. 1979 онд Эрдэнэт-Булган-Дашинчилэнгийн радио релейны шугам тавигдаж телевизийн тогтмол нэвтрүүлэг үздэг болсон.

Хангал сумын нутагт Зэс молбиден, хүдрийн баялаг орд нээгдэж, түүнийг даган шинэ суурин сүндэрлэсэн юм. 1974 онд Сайд нарын Зөвлөлийн тогтоолоор Булган аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргааны харьяанд Эрдэнэтийн хороо захиргаа байгуулагдан ажиллаж байгаад 1975 оны 12 дугаар сард улсын чанартай биеэ даасан хот байгуулсан юм. Улмаар Орхон аймаг болж манай аймгийн нутаг дотор охин аймаг төрсөн юм.

ХХ зууны манлай бүтээн байгуулалт манай аймгийн нутаг дэвсгэр дээр өрнөж, 1978 онд зэс, молибден, хүдрийн баялаг ордтой Монгол-Зөвлөлтийн уулын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэр ашиглалтанд орж, манай улсын хүнд аж үйлдвэрийн нэг том төв болон хөгжиж байна.

Булган аймгийн суурин хүн амын тоо 2012 оны жилийн эцсийн байдлаар 58651 байгаагаас 49,6 хувь нь эмэгтэйчүүд, 50,4 хувийг эрэгтэйчүүд эзэлж байна. Нийт хүн амын 12519 буюу 21.3 хувь нь аймгийн

төвд, 3145 буюу 5.4 хувь нь тосгонд, 14630 буюу 24.9 хувь нь сумын төвд, 28357 буюу 48.3 хувь нь хөдөөд оршин сууж байна.

Нийт 17159 өрхийн 3338 буюу 19,5 хувь нь аймгийн төвд, 917 буюу 5.3 хувь нь тосгонд, 4543 буюу 26.5 хувь нь сумын төвд, 8361 буюу 48.7 хувь нь хөдөөд байна. Хүн амын 96.4 хувь нь халх, 1.4 хувь нь буриад, 1.2 хувь нь баяд, бусад нь дархад, дөрвөд, өөлд, урианхай, захчин, хотгойд зэрэг угсаатны бүлгүүд байна.

Аймгийн нийт хүн амын 9.6 хувь нь дээд, 5.3 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 3.3 хувь нь техник мэргэжлийн, 25.5 хувь нь бүрэн дунд, 26.0 хувь нь суурь, 22.0 хувь нь бага боловсролтой.

Аймгийн хүн амын 64.9 хувь нь гар утас, 15.0 хувь нь интернет хэрэглэж байна

Булган аймаг улсдаа газар тариалангийн үйлдвэрлэлээр эхний 3, мал аж ахуйн үзүүлэлтээр 5, хүн амын хөгжлийн индексээр 7 дахь аймаг болон хөгжиж, улсын дотоодын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлтэд эзлэх үзүүлэлтээрээ бусад аймгаас дээгүүрт тооцогдож байна.



Булган аймагт нь газар тариалангийн гол бүс нутаг

Ууган гавъяатны өлгий Булган аймгаас 43 анхдагч төрж, аму тариа, айргаараа улсдаа алдартай.

XX зууны Монголын түүхэнд Булган аймаг алдар цуутай сайхан үйлсийн анхлан үүсгэн бүтээгч алдар гавъяатан олныг төрүүлэн гаргаснаараа өнөд мөнхрөх хүндтэй байр эзэлдэг билээ.

Газар зүйн байршил:

Хойт Монголын төв хэсэгт Хөвсгөл (Баруун, Баруун Хойд хэсгээрээ хилийн 1724 тоотоос Халзангийн худгийн гозгор хүртэл 290 км), Архангай (Баруун, Баруун Өмнөд хэсгээр Халзангийн худгийн гозгороос Цагаан Дэрс хүртэл 250 км), Өвөрхангай (Өмнөд хэсгээрээ Цагаан дэрснээс Салхитын холбоо хүртэл 30км), Төв (Өмнөд, Зүүн Өмнөд хэсгээр Салхитын холбоогоос Гэртийн тохой хүртэл 230 км), Сэлэнгэ (Зүүн, Зүүн хойд хэсгээр Гэртийн тохойгоос Хужиртын даваа хүртэл 220 км) болон Орхон аймгуудтай хиллэдэг ба ЗХУ-тай 1724 тоотоос Хужиртын даваа хүртэл 170 км урт газраар хиллэдэг байна. Аймгийн нийт талбай нь 48.8 мянган км.

Засаг захиргааны тухай:

Буган аймгийн нутаг нь XIII зууны үед Монголын эзэнт улсын харьяанд, Манжийн ноёрхолын болон Богд хаант Монгол улсын үед Халхын дөрвөн аймгийн нэг Түшээт хан аймагт, Ардын засгийн эхний жилүүдэд Богд хан уулын аймагт харьяалагдаж байлаа.

Одоогийн засаг захиргаа, нутаг дэвсгэр нь 1937 онд Сэлэнгэ аймгаас тасдан Булган аймгийн ихэнх нутгийг бүрдүүлэн, 15 сум, 43500 хүн амтай, 1.1 сая малтайгаар байгуулсан нь өнөөг хүрчээ. 16 сумтай, аймгийн төв Булган хот (Улаанбаатараас 318 км).

Уур амьсгал



Эх газрын эрс тэс уур амьсгалтай, жилийн дундаж агаарын температур (+1.5) хэм, хур тунадас 242.9 мм.

Улирлын ялгаа

Өвөл: ихэнхдээ тэнгэр цэлмэг, тогтвортой, хүйтэн, цас бага, салхины хүч бага байна. Агаарын хэм нэгдүгээр сард -46 хэм хүрдэг. Салхи нь зонхилон 1.9-2.5 м/с хурдтайгаар баруун хойд зүгээс салхилдаг.

Хавар: цаг агаар тогтворгүй, агаарын хэм түргэн өөрчлөгдөж хоногийн дулааны хэлбэлзэл ихэсч өдөртөө

дулаан, шөнөдөө хүйтэн болж ирдэг. Шороон шуурга олонтой болдог.

Зун: Энэ улирал нь хамгийн дулаан сар бөгөөд энэ нутагт хамгийн удаан

үргэлжилдэг улирал юм. Үнэмлэхүй дулаан нь +40.5 хэмд хүрдэг.

Намар: Намрын улиралд агаарын температурын хэлбэлзэл их боловч хаврынхтай адил биш байдаг. Цаг агаар тогтворгүй болж салхины хүч зунаас нэмэгддэг.

Усан хангамж :

Голуудын сүлжээний нягтшил Орхон, Сэлэнгийн бэсрэг уулс Хантай, Бүрэн, Бүтээл, Хан-Жаргалант, Булган хаан, Зэдийн нуруу зэргээр 300-500 м/км квадрат талбай нэлээд өмнүүр өргөрөгт орших Хөгнө хан, Авзага, Бүрэг, Заамар мэт тусдаа уулст 50-100 м/км квадрат буюу тэдгээрийн хоорондох өргөн уудам хөндий, хотос, ховдол, өнчин толгодод усны сүлжээний нягтшил 50 м/км квадрат заримд нь түүнээс ч бага байна. Нууруудын хувьд Сэлэнгийн сав нутагт нуур харьцангуй цөөн байдаг төдийгүй тэр тусмаа Булган аймагт Хөвсгөл, Архангай аймгуудыг бодвол харьцангуй бага байна. Хэдийгээр хур тунадас элбэг, ууршилт бага, гол мөрдийн сүлжээ ч гэсэн эрозийн эрч хүч, гадаргын налуу их учраас нуур цөөрөм бүрдэх нэг талын нөхцөл бага байгаа юм. Шарга, Цэгээн, Харгал, Айрхан зэрэг давстай нуур цөөнгүй бий.

Газрын гадарга:

Нутаг дэвсгэр нь Сэлэнгийн сав газарт бүхлээрээ хамрагдах бөгөөд тус сав газрыг Хангай, Хэнтий, Хөвсгөлийн уулс мөн Зэд, Зэлтэрийн асар өндөр нуруунууд цайз мэт хаяалан оршихийн зэрэгцээ түүний дотоодод Хангай, Хэнтийн уулсын бүтэцтэй холбоотой тус тусдаа орших уул нуруу олон, тэдгээрийг Орхон, Сэлэнгийн бэсрэг уулс гэнэ. Булган аймгийн нутагт орших тийм уулсын тоонд Одос, Намнан түүнээс өмнүүр Хөвсгөлийн нуруу болон зүүн тийшээ Булган хаан, Хан жаргалант, Бүрэн хийгээд Эг, Сэлэнгээс хойгуур Хантай, Бүтээлийн нуруу хилийн дагуу орших Зэдийн нуруу зэргийг нэрлэж болох бөгөөд эдгээр нь өргөрөг дагуу баруунаас зүүн тийш сунаж байрлах авч төдий л урт биш үнэмлэхүй өндөр нь уулархаг хэсэгтээ 1600-2171 метр, уул хоорондын хөндийд 600-1000 метр.



Уран тогоо уул /Хутаг-Өндөр сум/

Хантай, Бүрэн мэт арай томхон уулсын орой хавтгай бөмбөгөр байхад бусад нь элгэн хад цохио ил гарч, уулын торгон орой ар хажууд хүйтний өгөршлөөс үүссэн асган хүрээ, мөргөцөг мэр сэр үзэгдэнэ. Эндэх хотгор гүдгэрийн хөгжилд техтоник хөдөлгөөн чухал нөлөө үзүүлсэн. Хангай, Хэнтийн уулт их мужийн 2 дахь дэд муж болох “Орхон-Сэлэнгийн бэсрэг, нам уулсын муж”-нд бараг бүхлээрээ хамрагдаж байгаа юм. Энэ муж нь Хангай ба Хэнтийн уулт мужийн завсар байрлах, гадаргын байдал нь жигд биш, бэсрэг болон нам уулс, цав толгод, ухаа гүвээт тал, уулс хоорондын хотгор хослон оршино.

Ургамалшил:

Нутгийн хойт талыг тайгын бүслүүр эзлэнэ. Манай орны уур амьсгал эрс тэс, Төв азийн цөлийн хуурайсуулах нөлөө их учир ой тайга зөвхөн уулсын сүүдэрлэг хажууг барьж тааралддаг онцлогтой. Тайгын бүслүүрийн өмнөд хил нутгийн Сэлэнгэ мөрний хойт эргээр, Намнан уул, Хантай, Бүтээлийн нурууны ихэнхийг хамрана.

Нутгийн өмнөд хэсэг нь ойт хээрийн бүслүүрт хамруулан үздэг. Уул нурууны ойд сургар, нэрс, усан зээргэнэ, даль зэрэг сибирийн тайгын ургамал сөөгөн ташинга зэрэг ургамал түгээмэл ургаснаас гадна өвслөг ургамалтай шинэсэн ой ч хөвдөөр арвин, алирс, долоодой, ягжий, май цэцэг, чонын элэг зэрэг умардын тайгын ургамал ихтэй.

Тайгын хилээс өмнүүр ойт хээрийн бүс үргэлжилж нутгийн өмнөд хэсэг болох Могод болон Бүрэнгийн нурууны өмнөд бэл хүртэл үргэлжлэнэ.



Байгалын үзэсгэлэнт газар “Элсэн тасархай” /Рашаант сум/

Энэ нутагт уулын тайга, уулын ойт хээрийн, хээрийн ургамалжилтын гурван бүс, бүслүүр байгаагийн 2 нь уулархаг нөхцөлтэй уялдан үүссэн босоо бүслүүр юм.

Амьтны аймаг:

Ойн амьтан: Ойн тархмал мэрэгчийн нэг хэрэм гол тэжээлээ дагаж хушин ойд хамгийн элбэг байна. Ойн зах унанги дархи, асга чулуутай хэсэгт жирх элбэг. Туурайтнаас бор гөрөөс, буга, зэрлэг гахай бүх ойт нугийн энгэрээр тархмал гэж болно. Харин одоо эдгээр амьтны тархац, тоо толгойн байдал хүний нөлөөнөөс ихээхэн шалтгаалж аль болох зэлүүд нутаг руу түрэгдэн газар бүр харилцан адилгүй болж байна.

Аймгийн хамгийн хойд хэсэгт тайгын өндөр уулсын ар хажуугаар хүдэр нутаглана.

Хантай, Бүрэн, Бүтээлийн нуруугаар хандгай, хүрэн баавгай, булга, нохой зээх нутаглана. Агнуураас шалтгаалан булга нэг үе их ховордсон ч өсч байна.

Хээрийн амьтан : Уулын өмнөд өвөр хажуу бэл голын хөндийн ой модгүй задгай газарт идээшсэн олон зүйл амьтан бий. Энд 16-17 зүйл мэрэгч тохилдохоос тарвага, урт сүүлт зурам, сибирийн алга даага, үлийн цагаан оготно, үлийн бор оготно бусдаас элбэг байна.



Түүхэн дурсгалт газар Цогтын балгас /Дашинчилэн сум/

Шавьж идэштнээс дагуурын зараа, хонин малтаахай хоёр голын татам дэнж бэл хөндийгөөр тохилддог. Жижиг мэрэгч шувуу элбэг байгаа нь энд хярс, өмхий хүрэн зэрэг махан идэштэн олон байх нөгцөл болжээ. Хад чулуутай уулсаар мануул ховор биш үзэгдэнэ.

Ус намгийн амьтан: Орхон, Сэлэнгэ голуудын адгаар ондоотор нилээд тархсан. Мөн Эг, Сэлэнгийн саваар заарт харх элбэг. Загас: Сэлэнгэ, Орхон, Эгийн гол зэрэг томоохон голын зөөлөн урсгалт гүнзгий цээлийн элс шаварлаг ёроолд 3 м урт, 100 гаруй кг хүрдэг манай орны хамгийн том загас сибирийн хилэм тохиолдоно.

Хадрангийн төрлийн загас хамгийн элбэг тархсан байдаг. Зэвэг, цурхай голын намуун урсгалт булан тохойн өвс ургамалтай хэсэгт байнга байна. Сэлэнгийн савд Хар мөрний цулбуурт, булуу цагаан засаг элбэг тархсан.

Эдгээрээс гадна улаан нүдэн, гутаар, алгана, бух сугас, мөнгөлөг хэлтэг зэрэг 10 гаруй зүйл загас тархсан.

Улаан номд орсон амьтад: Хандгай (Хантай, Бүтээлийн нуруугаар нутагшина),

Хошуу галуу (Орхон, Сэлэнгэ голуудын дагуу амьдардаг, өндөр өвс ургамалтай дов намгаар хүрээлэгдсэн бургас, шагшуурга олон арал бүхий голуудын дагуу зусдаг), Тоодог (аймгийн зарим зэлүүд талд цөөн тоогоор тааралдана.), Хилэм (Сэлэнгэ мөрөнд тархсан байх бөгөөд Байгаль нуурын сав газраас үржих хугацаандаа манай нутагт нүүдэллэн ирж түрсээ шахдаг).

Ахуй соёл:

Энэ нутагт Халх /96.3%/ түмний амьдралын хэв маяг, ёс заншил зонхилдог. Буриад /1.9%/, Өөлд /1.4%/, дөрвөд, дархад, баяд зэрэг цөөнх ястантайгаа хамтаар оршин байгалийн нөхцөл, нийгэм эдийн засгийн орчиндоо зохицсон аж ахуй, үйлдвэрлэл эрхлэн, өөр өөрсдийн өвөрмөц онцлог орон сууц, суурин газар, орчинг үүсгэн амьдардаг онцлогтой. Эдгээрээс зонхилох хоёр ястан нь нутгаар ялгаран аж төрөх бөгөөд Халх ястан нь аймгийн Тэшиг сумаас бусад газар жигд тархсан байхад Тэшиг суманд нь цөөнх болсон буриадууд нь төвлөрөн суурьшдаг байна.



Энэ нутгаар аялахад олон ястаны өвөрмөц ахуйг ажиглах бөгөөд буриадуудын хагас суурин хэлбэрээр амьдарч, гар аргаар цөцгий цохих, морин хадуураар өвс хадах, таваарлаг чанарын цөөн тооны мал аж ахуй эрхлэн, дуу хуур, бүжиг наадам бүхий сайхан найр наадам хийж, өөрсдийн аялгуугаараа ялгарч байдаг нь ихээхэн сонирхолтой байдаг. Энэ мэтчилэн онцлог ахуй шинжээ эртнээс уламжилж ирсэн бөгөөд одоо ч хэвээр хадгалсаар байна.

ХҮН АМ ЗҮЙН БАЙДАЛ

Бүлэг 1



I. ХҮН АМЫН ТОО, НАС ХҮЙСИЙН БҮТЭЦ

Аймаг, сумын нутаг дэвсгэрийн хэмжээ харилцан адилгүйн зэрэгцээ газар зүйн янз бүрийн бүсэд оршдог, байгалийн баялаг, нутаг дэвсгэрт жигд бус тархсан зэргээс хамааран хүн амын суурьшил, нягтрал, хөгжлийн төвшин өөр өөр байгаа нь зүй ёсны асуудал юм.


Хүн амын үзүүлэлтүүдийг нарийн тодорхойлох нь тухайн нутаг дэвсгэрийн нийгэм эдийн засгийн хөгжлийг гүнзгийрүүлэн судалж, орон нутгийн онцлогт тохирсон бодлого боловсруулах үндэс нь болно.

Хүн амын тоо түүний өсөлт

Хүн амын тооны өөрчлөлтийг төрөх, нас барах, шилжих хөдөлгөөнөөр тодорхойлдог. 2013 оны хүн амын шинэчилсэн бүртгэлийн дүнгээр аймгийн нийт суурин хүн амын тоо, өрхийн тоо 17549 өрхийн 58888 хүн ам бүртгүүлсэн байна.

Энэ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал өрх 2,3 хувиар, хүн ам 0,4 хувиар тус тус өссөн байна. Тайлант онд Иргэний бүртгэлийн дүнгээр 1426 хүүхэд шинээр мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс 10,1 хувиар өссөн байна. Хариан нас барсан хүний тоо 363 болж өнгөрсөн оны мөн үеэс 5,0 хувиар буурсан бол 2031 хүн шилжин ирсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 3,5 дахин өсөж, 2718 хүн шилжин явсан нь өнгөрсөн оны мөн үеэс 2,4 дахин өссөн дүнтэй байна. Дотоод шилжих хөдөлгөөн нэмэгдэж байгаа нь аймгийн хүн амын тоонд ихээхэн нөлөөлж байна.

Зураг 1. Суурин хүн амын тоо, оноор



Хүснэгт 1. Өрхийн тоо, суурин хүн амын тоо, сумаар, оноор

| Сумын нэр | Өрхийн тоо | | | Хүн амын тоо | | |
|-----------|------------|-------|-------|--------------|-------|-------|
| | 2011 | 2012 | 2013 | 2011 | 2012 | 2013 |
| Бүгд | 17054 | 17160 | 17549 | 58483 | 58651 | 58888 |
| Булган | 3356 | 3338 | 3434 | 12450 | 12519 | 12010 |

| | | | | | | |
|-------------|------|------|------|------|------|------|
| Баян-Агт | 843 | 858 | 880 | 3035 | 3050 | 3076 |
| Баяннуур | 466 | 490 | 495 | 1691 | 1724 | 1749 |
| Бугат | 602 | 620 | 691 | 1819 | 1848 | 2011 |
| Бүрэгхангай | 765 | 782 | 815 | 2547 | 2540 | 2549 |
| Гурванбулаг | 897 | 897 | 950 | 3128 | 3123 | 3243 |
| Дашинчилэн | 798 | 788 | 810 | 2407 | 2550 | 2666 |
| Могод | 805 | 800 | 794 | 2692 | 2677 | 2655 |
| Орхон | 953 | 958 | 1031 | 2830 | 2790 | 3093 |
| Рашаант | 940 | 947 | 950 | 3168 | 3164 | 3168 |
| Сайхан | 1086 | 1069 | 1058 | 3648 | 3628 | 3602 |
| Сэлэнгэ | 951 | 975 | 992 | 3340 | 3363 | 3361 |
| Тэшиг | 921 | 941 | 901 | 3431 | 3424 | 3415 |
| Хангал | 1336 | 1349 | 1375 | 4524 | 4518 | 4527 |
| Хишиг-Өндөр | 1019 | 1018 | 1018 | 3144 | 3104 | 3132 |
| Хутаг-Өндөр | 1316 | 1330 | 1355 | 4629 | 4629 | 4631 |

Аймгийн хэмжээнд хамгийн их хүн амтай суурьшиж байгаа нь Булган сум 12010 буюу нийт хүн амын 20,3 хувь нь амьдарч байна. 2013 оны жилийн эцсийн байдлаар сумдаас хамгийн их хүн амтай сум Хутаг-Өндөр сум 4631 хүн амтай буюу хийт хүн амын 7,9 хувийг эзэлж байгаа бол хамгийн бага хүн амтай сум Баяннуур сум 1749 хүн амтай байна. Дундажаар нэг суманд 3681 хүн ногдож байна. Харин нэг өрхөд дундажаар 3,6 хүн ногдож байна. Булган сумын нэг өрхөд дундажаар 3,5 хүн ногдож байна.

Хүснэгт 2. Аймгийн хүн амын тоо, тооллого явагдсан оноор, хүйсээр

| Тооллого явагдсан он | Хүн амын тоо | | | Хүйсийн харьцаа |
|----------------------|--------------|---------|---------|-----------------|
| | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй | |
| 1956 | 30947 | 15312 | 15635 | 97.9 |
| 1963 | 33127 | 16743 | 16384 | 102.2 |
| 1969 | 37373 | 18937 | 18436 | 102.7 |
| 1979 | 42378 | 21608 | 20770 | 104.0 |
| 1989 | 51910 | 26230 | 25680 | 102.1 |
| 2000 | 61776 | 31153 | 30623 | 101.7 |
| 2010 | 53653 | 27621 | 26032 | 106.1 |

Хүн ам орон сууцны 2010 оны Булган аймгийн нэгдсэн дүнгээс

Дээрх хүснэгтээс харахад 1956-1963 оны хоорондох 7 жилийн хугацаанд 7,0 хувиар, 1963-1969 оны хоорондох 7 жилийн хугацаанд 12,8 хувиар, 1969-1979 оны хоорондох 11 жилийн хугацаанд 13,4 хувиар, 1979-1989 оны хоорондох 11 жилийн хугацаанд 22,4 хувиар, 1989-2000 оны хоорондох 11 жилийн хугацаанд 19,0 хувиар өсч байсан бол 2000-2010 оны хоорондох 11 жилийн хугацаанд 13,1 хувиар буурсан байна. Эндээс харахад 2000 хүртэл аймгийн хүн ам тогтвортой өсч байснаа 2000 оноос хойш өсөлт нь саарч буурах хандлагатай болсон байна.

❖ Хүн амын ердийн цэвэр өсөлт

Доорхи хүснэгтээс харахад аймгийн хэмжээнд хүн амын цэвэр өсөлт 2013 онд төрөлт өмнөх оноос 10,11 хувиар өсч, нас баралт 4,97 хувиар буурч, хүн амын ердийн цэвэр өсөлт 16,42 хувиар өссөн байна. 1999 оноос хойшхи 15 жилийн хугацаанд хамгийн их төрөлт бүртгэгдсэн нь 2013 онд 1426 хүүхэд төрсөн байна. Сүүлийн жилүүдэд төр засгаас хэрэгжүүлж байгаа залуучууд, гэр бүлийг дэмжих зөв бодлогын дүнд хүн амын цэвэр өсөлт нэмэгдэж байна гэж үзэж болно.

Хүснэгт 3. Хүн амын цэвэр өсөлт, оноор

| Он | Төрөлт | Нас баралт | Цэвэр өсөлт |
|-------------|---------------|-------------------|--------------------|
| 1998 | 1246 | 368 | 878 |
| 1999 | 1176 | 350 | 826 |
| 2000 | 1233 | 293 | 940 |
| 2001 | 1285 | 387 | 898 |
| 2002 | 1158 | 382 | 776 |
| 2003 | 1068 | 357 | 711 |
| 2004 | 907 | 378 | 529 |
| 2005 | 918 | 343 | 575 |
| 2006 | 989 | 340 | 649 |
| 2007 | 1081 | 335 | 746 |
| 2008 | 1250 | 347 | 903 |
| 2009 | 1399 | 381 | 1018 |
| 2010 | 1264 | 415 | 849 |
| 2011 | 1336 | 385 | 951 |
| 2012 | 1295 | 382 | 913 |
| 2013 | 1426 | 363 | 1063 |

Зураг 2. Хүн амын төрөлт, нас баралт



❖ **Хүн амын нас хүйсийн бүтэц**

Сүүлийн 10 гаруй жил хүн ам нас хүйсийн бүтэц ихээхэн өөрчлөлт орж байгаа бөгөөд хүн ам залуужих хандлагатай байна.


Хүн амын насны хүтэц нь хүн амын хөгжлийн асуудлыг харуулдаг гол үзүүлэлтийн нэг юм. Аймгийн хүн амын нас хүйсийн бүтцийг харуулбал нийт суурин хүн амын 49,57 хувь буюу 29196 эмэгтэй хүн байна. Насны бүлгээр нь харахад 0-15 насны хүүхэд 16966 буюу нийт хүн амын 28,81 хувийг, 16-59 хүн ам 38266 буюу 64,98 хувийг, 60-аас дээш насны хүн ам 3656 буюу 6,20 хувийг эзэлж байна.

Хүснэгт 4. Хүн амын тоо, насны бүлгээр, хүйсээр, 2013 он

| Насны бүлэг | Хүн ам | Үүнээс | | Хүйсийн харьцаа |
|-------------|--------|---------|---------|-----------------|
| | | Эрэгтэй | Эмэгтэй | |
| Бүгд | 58888 | 29692 | 29196 | 101.70 |
| 0-15 | 16966 | 8706 | 8260 | 105.40 |
| 16-59 | 38266 | 19339 | 18927 | 102.17 |
| 60+ | 3656 | 1647 | 2009 | 121.97 |

❖ **Хүйсийн харьцаа гэдэг нь 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоо юм.**


Зураг 3. Хүн амын тоо насны бүлгээр, хувиар, 2013 он



Хүйсийн харьцаа 60-аас дээш наснаас буурч байгаа нь эрэгтэйчүүдийн нас баралт эмэгтэйчүүдийхээс харьцангуй илүү байгаатай холбоотой юм.

Хүн амын нас хүйсийн бүтцийг харуулах өөр нэг гол үзүүлэлт бол хүн амын нас хүйсийн суварга юм.

Зураг 4. Хүн амын нас хүйсийн суварга




Хүн амын нас хүйсийн суваргаас харахад 2013 оны суваргын суурь өргөн байгаа нь сүүлийн жилүүдэд төрөлт нэмэгдсэнтэй холбоотой юм. Мөн 2008 онд 15-19 насанд өргөн байсан бол 2013 онд 20-24 насанд өргөн байгаа манай хүн ам залуужиж байгааг харуулж байгаа эерэг үзүүлэлт юм. Суваргаас харахад 25-аас дээш насанд суварга аажмаар нарийсаж байгаа нь насны бүлэг ахих тутам нас баралтын нөлөөгөөр тухайн насан дахь хүн амын тоо буурч байгаагаар тайлбарлаж болно.

III. ХҮН АМЫН ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨН

Хүн ам зүйн шинжлэх ухаанд “Төрөлт” хэмээх ойлголтыг авч үзэхдээ тухайн эмэгтэйн төрүүлсэн хүүхдийн тоогоор илэрхийлдэг. Төрөлтийг судлахдаа төрөх чадавхи, нөхөн үржихүй, төрөлтийн дарааллыг мэдэх шаардлагатай. Сүүлийн 5 жилийн дундажаар төрөлтийг тооцвол жилд дундажаар 1344 хүүхэд шинээр мэндэлж байна.

❖ Төрөлт

Зураг 5. Төрөлт 2009-2010 он




Хүснэгт 5. Төрөлтийн болон нөхөн үржихүйн коэффициент, оноор

| Насны бүлэг | 2009 | 2010 | 2011 | 2012 | 2013 |
|-------------|-------|-------|-------|-------|-------|
| 15-19 | 3250 | 2894 | 2759 | 2959 | 2713 |
| 20-24 | 3141 | 2958 | 3005 | 3005 | 2817 |
| 25-29 | 2455 | 2364 | 2315 | 2315 | 2315 |
| 30-34 | 2300 | 2304 | 2178 | 2178 | 2214 |
| 35-39 | 2226 | 2227 | 2204 | 2204 | 2197 |
| 40-44 | 2049 | 2118 | 2121 | 2121 | 2114 |
| 45-49 | 1891 | 1874 | 1872 | 1872 | 1958 |
| ТЕК | 23.78 | 21.66 | 22.84 | 22.08 | 24.22 |
| ТТК | 80.8 | 75.5 | 81.2 | 77.8 | 87.3 |

**ТЕК- Төрөлтийн ерөнхий коэффициент

**ТТК- Төрөлтийн тусгай коэффициент



2013 онд аймгийн хэмжээнд 1426 эхээс 1426 хүүхэд төрсөн байна. Тайлант хугацаанд 0-1 насны хүүхдийн эндэгдэл 18 гарсан нь өмнөх оны мөн үетэй адил, 1-5 насны хүүхдийн эндэгдэл 3 гарсан нь өмнөх оны мөн үеэс 2 тохиолдлоор буюу 3 дахин өссөн үзүүлэлттэй байна. Эхийн эндэгдэл энэ онд гараагүй бөгөөд нийт нас баралт 363 гарсан нь өмнөх оны мөн үеэс 4.97 хувиар буурсан байна.

Хүснэгт 6. Төрөлт, нас баралтын үзүүлэлт, харьцуулсан оноор

| Үзүүлэлтүүд | 2012 | | 2013 | |
|-----------------------------|-----------|--------------|-----------|--------------|
| | Бодит тоо | 1000 хүн амд | Бодит тоо | 1000 хүн амд |
| Нийт хүн ам | 58651 | | 58888 | |
| Төрсөн эх | 1295 | | 1426 | |
| Амьд төрсөн нярай | 1295 | | 1426 | |
| Нийт нас баралт | 382 | | 363 | |
| 0-1 насны хүүхдийн эндэгдэл | 18 | 0.31 | 18 | 0.31 |
| 1-5 насны хүүхдийн эндэгдэл | 1 | 0.02 | 3 | 0.05 |
| Эхийн эндэгдэл | 0 | 0 | 0 | 0 |
| Амьгүй төрөлт | 4 | 0.07 | 5 | 0.08 |
| Гэрийн төрөлт | 3 | 0.05 | 6 | 0.10 |
| Хяналтгүй төрөлт | 0 | 0 | 0 | 0 |

**Мэдээллийн эх сурвалж- аймгийн Эрүүл мэндийн газар

Тайлант онд төрөлт өмнөх оны мөн үеэс 131-ээр нэмэгдсэн байна. 0-1 насны хүүхдийн эндэгдэл Булган суманд хамгийн их буюу 4 тохиолдол гарч 3.33 промилл байна. Гэрийн төрөлт өмнөх оны мөн үеэс 1 дахин өссөн байна.

Зураг 7. 0-1 насны хүүхдийн эндэгдэл, насны бүлгээр, өмнөх онтой харьцуулбал



❖ **Гэрлэлт, гэр бүл цуцлалт, хүүхэд үрчлэлт**

Аймгийн иргэний бүртгэлийн дүнгээр 2013 онд 269 хос гэрлэлтээ батлуулсан нь өмнөх оны мөн үеэс 65 хосоор буюу 21.38 хувиар 2009 оны мөн үеэс 40.86 хувиар буурсан байна. Мөн гэр бүл цуцлалт 51 бүртгэгдэж өмнөх оны мөн үеэс 34.21 хувиар, хүүхэд үрчлэлт өмнөх оны мөн үеэс 12.24 хувиар тус тус өссөн байна.

Хүснэгт 7. Гэрлэлт, гэр бүл цуцлалт, оноор

| Он | Гэрлэлт | Цуцлалт | Он | Гэрлэлт | Цуцлалт |
|------|---------|---------|------|---------|---------|
| 1994 | 841 | 10 | 2004 | 278 | 3 |
| 1995 | 403 | 4 | 2005 | 500 | 12 |
| 1996 | 382 | 6 | 2006 | 1281 | 11 |
| 1997 | 338 | 4 | 2007 | 985 | 21 |
| 1998 | 307 | 7 | 2008 | 604 | 27 |
| 1999 | 429 | 4 | 2009 | 624 | 36 |
| 2000 | 267 | 9 | 2010 | 226 | 82 |
| 2001 | 515 | 14 | 2011 | 292 | 63 |
| 2002 | 300 | 4 | 2012 | 306 | 38 |
| 2003 | 360 | 10 | 2013 | 51 | 55 |

Зураг 8. Гэрлэлт, цуцлалт, хүүхэд үрчлэлт, 2013 он

| Он | Гэрлэлт | Цуцлалт | Он | Гэрлэлт | Цуцлалт |
|------|---------|---------|------|---------|---------|
| 1994 | 841 | 10 | 2004 | 278 | 3 |
| 1995 | 403 | 4 | 2005 | 500 | 12 |
| 1996 | 382 | 6 | 2006 | 1281 | 11 |
| 1997 | 338 | 4 | 2007 | 985 | 21 |
| 1998 | 307 | 7 | 2008 | 604 | 27 |
| 1999 | 429 | 4 | 2009 | 624 | 36 |
| 2000 | 267 | 9 | 2010 | 226 | 82 |
| 2001 | 515 | 14 | 2011 | 292 | 63 |
| 2002 | 300 | 4 | 2012 | 306 | 38 |
| 2003 | 360 | 10 | 2013 | 269 | 51 |

Зураг 9. Гэрлэлт, цуцлалт, хүүхэд үрчлэлт, 2013 он



❖ Өрхийн тоо, сууцны төрөл, нэг өрхөд ногдох хүний тоо

Аймгийн хэмжээнд 2012 оны байдлаар 17549 өрх тоологдсон байна. Нийт өрхийн 9751 буюу 55.56 хувь нь гэрт амьдарч байна. Аймгийн хувьд гэр хороолол ихтэй байна. Монгол уламжлалаар гэрт ихэвчлэн нийлмэл өрхүүд амьдардаг.

Зураг 9. Өрхийн тоо, сууцны төрлөөр, 2013 он



Хүснэгт 8. Өрхийн тоо, сууцны төрлөөр, 2013 он

| Сууцны төрөл | | Өрхийн тоо |
|--------------------------------|-------------------------|------------|
| Гэрт амьдардаг өрхийн тоо | | 9751 |
| Байшинд суудаг өрхийн тоо-бүгд | | 7738 |
| Үүнээс | Орон сууцны байшинд | 424 |
| | Бие даасан тохилог сууц | 12 |
| | Сууцны тусдаа байшин | 6968 |
| | Нийтийн байр | 334 |
| Бусад сууцны тоо | | 60 |

Хүснэгт 9. Өрхийн тоо, сумаар, оноор

| Сум | 2009 | 2010 | 2011 | 2012 | 2013 | $\frac{2013}{2012}$ % |
|-------------|-------|-------|-------|-------|-------|-----------------------|
| Бүгд | 16742 | 16786 | 17054 | 17160 | 17549 | 102.3 |
| Булган | 3296 | 3299 | 3356 | 3338 | 3434 | 102.9 |
| Баян-Агт | 830 | 839 | 843 | 858 | 880 | 102.6 |
| Баяннуур | 414 | 454 | 466 | 490 | 495 | 101.0 |
| Бугат | 613 | 550 | 602 | 620 | 691 | 111.5 |
| Бүрэгхангай | 698 | 729 | 765 | 782 | 815 | 104.2 |
| Гурванбулаг | 876 | 891 | 897 | 897 | 950 | 105.9 |
| Дашинчилэн | 755 | 777 | 798 | 788 | 810 | 102.8 |
| Могод | 810 | 803 | 805 | 800 | 794 | 99.3 |
| Орхон | 976 | 970 | 953 | 958 | 1031 | 107.6 |
| Рашаант | 922 | 942 | 940 | 947 | 950 | 100.3 |
| Сайхан | 1096 | 1091 | 1086 | 1069 | 1058 | 99.0 |
| Сэлэнгэ | 901 | 915 | 951 | 975 | 992 | 101.7 |
| Тэшиг | 954 | 919 | 921 | 941 | 901 | 95.7 |
| Хангал | 1340 | 1314 | 1336 | 1349 | 1375 | 101.9 |
| Хишиг-Өндөр | 1018 | 1021 | 1019 | 1018 | 1018 | 100.0 |
| Хутаг-Өндөр | 1243 | 1272 | 1316 | 1330 | 1355 | 101.9 |

2013 оны жилийн эцсийн байдлаар нийт өрхийн тоо өмнөх оны мөн үеэс 2,3 хувиар өссөн байна. аймгийн хэмжээнд орон сууцны хүрэлцээ бага учраас нийт өрхийн дийлэнх нь гэр хороололд болон сууцны байшинд амьдарч байна. 1 өрхөд ногдох хүний тоо 3,4 байна.


❖ Хүн амын тархан суурьшилт, нягтралт

3 □□□□□ □□□□□□ 48.5 □□□□□ □2 □□□□□□□□□□□□ □□□□□ □□□□□□ □□□□ 1 □□ □□□□□□ □□□□□□ 1.21 □А □□□□□□ □□□□□ Энэ нь хүн амын нягтрал харьцангуй бага байгааг харуулж байна. Хүн амын нягтрал хамгийн их сум Хангал сум 1км2 45.27 хүн ногдож байна.

Хүснэгт 10. Газар нутгийн хэмжээ, сумаар, 2013 он

| | Хүн амын | | Нутаг дэвсгэр | | 1 км2 ногдох хүн |
|-------------|--------------|--------------|---------------|--------------|------------------------|
| | Тоо | Эзлэх хувь | Км2 | Эзлэх хувь | |
| Бүгд | 58888 | 100.0 | 48531 | 100.0 | 1.21 |
| Булган | 12010 | 20.39 | 3079 | 6.34 | 3.90 |
| Баян-Агт | 3076 | 5.22 | 3004 | 6.19 | 1.02 |
| Баяннуур | 1749 | 2.97 | 3498 | 7.21 | 0.50 |
| Бугат | 2011 | 3.41 | 2686 | 5.53 | 0.75 |
| Бүрэгхангай | 2549 | 4.33 | 2319 | 4.78 | 1.10 |
| Гурванбулаг | 3243 | 5.51 | 2620 | 5.40 | 1.24 |
| Дашинчилэн | 2666 | 4.53 | 4215 | 8.69 | 0.63 |
| Могод | 2655 | 4.51 | 2773 | 5.71 | 0.96 |
| Орхон | 3093 | 5.25 | 4829 | 9.95 | 0.64 |
| Рашаант | 3168 | 5.38 | 7720 | 15.91 | 0.41 |
| Сайхан | 3602 | 6.12 | 1656 | 3.41 | 2.18 |
| Сэлэнгэ | 3361 | 5.71 | 2455 | 5.06 | 1.37 |
| Тэшиг | 3415 | 5.80 | 5605 | 11.55 | 0.61 |
| Хангал | 4527 | 7.69 | 100 | 0.21 | 45.27 |
| Хишиг-Өндөр | 3132 | 5.32 | 960 | 1.98 | 3.26 |
| Хутаг-Өндөр | 4631 | 7.86 | 1012 | 2.09 | 4.58 |

Зураг 10. Газар нутгийн хэмжээ, хүн амын суурьшил, сумаар, 2010



**Хүн ам орон сууцны тооллогын дүн*

❖ Хүн амын шилжилт хөдөлгөөн

2013 оны байдлаар бүртгүүлсэн шилжин ирэгсдийн тоо 2031 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 2,9 дахин нэмэгдсэн байна. Бүртгүүлсэн шилжин ирэгсдийн 58,39 хувь нь аймаг хоорондын шилжин ирэгсэд байна. Мөн тайлант хугацаанд бүртгүүлсэн шилжин явагсад 2718 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 2,0 дахин өссөн байна. Нийт бүртгүүлсэн шилжин явагсадын 68,65 хувь нь аймаг, хоорондын шилжин шилжин явагсад байна. Нийт шилжин явагсадын 1056 буюу 55,92 хувь нь эмэгтэйчүүд байна.

Хүснэгт 11. Шилжилт хөдөлгөөний цэвэр коэффициент, 2013 он

| Сумын нэр | Шилжин ирсэн хүн ам | Шилжин явсан хүн ам | Шилжилт хөдөлгөөний цэвэр коэфф |
|-------------|---------------------|---------------------|---------------------------------|
| Бүгд | 2031 | 2718 | -11.7 |
| Булган | 463 | 734 | -22.1 |
| Баян-Агт | 92 | 122 | -9.8 |
| Баяннуур | 87 | 80 | 4.0 |
| Бугат | 208 | 108 | 51.8 |
| Бүрэгхангай | 110 | 131 | -8.3 |
| Гурванбулаг | 86 | 122 | -11.3 |
| Дашинчилэн | 97 | 91 | 2.3 |
| Могод | 47 | 109 | -23.3 |
| Орхон | 138 | 69 | 23.5 |
| Рашаант | 112 | 162 | -15.8 |
| Сайхан | 49 | 107 | -16.0 |
| Сэлэнгэ | 96 | 170 | -22.0 |
| Тэшиг | 74 | 138 | -18.7 |
| Хангал | 160 | 276 | -25.6 |
| Хишиг-Өндөр | 75 | 145 | -22.5 |
| Хутаг-Өндөр | 137 | 154 | -3.7 |

Зураг 11. Шилжилт хөдөлгөөний урсгал, 2013 он



IV. ӨРХ ХҮН АМ НИЙГМИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ

Өрхийн хэлбэрээр буюу өрхөд тоологдсон хүн ам, өрхийн тэргүүлэгчтэй ямар хамааралтайгаар нь өрхийг ангилан харуулах нь нийгэм, хүн ам зүй, эдийн засгийн судалгаанд болон бодлого боловсруулагчид нилээд сонирхолтой болдог.

Өрхийн дөрвөн хэлбэр байдаг. Үүнд:

- ✓ Ганц бие өрх
- ✓ Ам бүлээрээ байгаа өрх
- ✓ Нийлмэл өрх
- ✓ Холимог өрх

Манай орны хувьд нийлмэл ам бүлтэй өөрөөр хэлбэл эцэг эх, ах, дүүс, садан төрлөөрөө сууж байгаа өрх олон байдаг. Энэ нь өрхийн бүлийн бүтцийн түгээмэл хэлбэр бөгөөд үр хүүхэд, хамаатан садантайгаа хамт амьдрах нь манай уламжлалт заншилтай холбоотой гэж үзэж болно.

Хүснэгт 12. Өрхийн тоо, өрхөд тоологдсон хүний тоо, өрхийн хэлбэрээр, 2013 он

| Ам бүлийн тоо | Өрх-Бүгд | Үүнээс: өрхийн хэлбэрээр | | | |
|---------------|--------------|--------------------------|--------------|----------------|----------------|
| | | Ганц бие | Ам бүлээрээ | Нийлмэл ам бүл | Холимог ам бүл |
| Бүгд | 15807 | 1992 | 10991 | 2544 | 280 |
| 1 | 1992 | 1992 | 0 | 0 | 0 |
| 2 | 3081 | 0 | 2614 | 425 | 42 |
| 3 | 3845 | 0 | 3214 | 568 | 63 |
| 4 | 3866 | 0 | 3206 | 596 | 64 |
| 5 | 2055 | 0 | 1490 | 513 | 52 |
| 6 | 717 | 0 | 372 | 307 | 38 |
| 7 | 167 | 0 | 71 | 84 | 12 |
| 8 | 60 | 0 | 18 | 34 | 8 |
| 9 | 15 | 0 | 5 | 9 | 1 |
| 10 | 5 | 0 | 1 | 4 | 0 |
| 11 | 1 | 0 | 0 | 1 | 0 |
